

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,  
АЛБАН ТУШААЛТАНД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ  
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР 2010 ОНД  
ЗОХИОСОН АЖЛЫН ТАЙЛАН**

2011.01.03

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн ЗДТГ нь “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67-р тогтоол, 2007 оны 8-р албан даалгавар, аймгийн Засаг даргын 2009 оны 54-р захирамжаар батлагдсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх журам” болон холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, сум, хэлтэс агентлагуудаа мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажиллахын зэрэгцээ, дүнг Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн “Мэдээллийн самбар”-т байрлуулж, сумд, хэлтэс, агентлагуудын үйл ажиллагааг идэвхижүүлэн ажиллаж байна.

2010 онд аймгийн хэмжээнд нийт 58577 иргэний санал, өргөдөл гомдол хүлээн авч, 58077 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг амаар болон бичгээр өгсөн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй 500 өргөдөл байгаа бөгөөд өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 99.1 %-тай байна. / Хүснэгт 1 /

Үүнээс аймгийн Засаг даргын Тамгын газар нийт 502 иргэний өргөдлийг хүлээн авч, 496 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсний дотор 135 буюу нийт өргөдлийн 26.8 хувийг нь харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлэсэн байна. Тухайлбал: Сумдад- 31, Захирагчийн албанд-27, ГХБХБГ-45, ЭМГ-4, ХХААЖДҮГ-1, МХГ-3, ХХҮХ-4, ТАЗСЗ-10, ТАЗГ-2, НДХ-1, ЦШтаб-2, Үйлдвэрчний эвлэл-1, Цагдаагийн газарт-4 иргэний өргөдөл, хүсэлтийг тус тус шилжүүлэн шийдвэрлэсэн байна.

Аймгийн ЗДТГ энэ хугацаанд боловсрол, соёлын асуудлаар 19, эрүүл мэнд, спортын чиглэлээр 19, нийгмийн хамгааллын чиглэлээр 21, нийт 59 хүсэлт Нийгмийн хөгжлийн хэлтэст, мөнгөн тусламж хүссэн болон төрийн санхүүгийн асуудлаар 52 хүсэлт Санхүү, Төрийн Сангийн Хэлтэст, хууль зүйн зөвөлгөө мэдээлэлтэй холбоотой асуудлаар 16 хүсэлт Хуульзүйн Хэлтэст, дээвэр, сантехник, жижиг, дунд үйлдвэрлэлтэй холбоотой асуудлаар 37 хүсэлт Хөгжлийн Бодлогын Хэлтэст, орон гэр, буцалтгүй тусламж, ахмадын харьяалал, ажлын байр хүсэх тухай, иргэний шинэчилсэн бүртгэл болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлаар нийт 338 гомдол, хүсэлт Төрийн Захиргаа Удирдлагын Хэлтэст тус тус шийдвэрлэгдсэн байна.

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль”-д заасны дагуу иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх, харилцан ярилцах, санал сэтгэгдлээ хэнээс ч

хараат бус чөлөөтэй илэрхийлэх боломж бүхий үйлчлүүлэгч иргэдийн ая тухтай байдлыг хангасан “Иргэдийг хүлээн авах өрөө”-г 2010 оны 3-р сараас эхлэн нээн ажиллуулж, **240** иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, **208** иргэнд биечлэн болон утсаар зөвлөгөө, үйлчилгээ үзүүллээ. Иргэдийг хүлээн авах өрөө нь иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, уулзаж, ярилцах нөхцлийг бүрдүүлэхээс гадна төр засгийн бодлого, шийдвэр, орон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд хүргэх, мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангахад ач холбогдлоо өгч байна. Мөн иргэд Төрийн мэдээлэл, Хуульзүйн мэдээлэл сэтгүүлээс хуульзүйн лавлагааг шуурхай хүлээн авч байгаа нь үр дүнгээ өгч байна.

“Иргэдийг хүлээн авах өрөө”-ний үйл ажиллагааг өргөжүүлэх, бизнес эрхлэгчдэд төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөртэй хамтран төрөөс үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан “Бизнес ширээ”-ний үйлчилгээг 2010 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс аймгийн ЗДТГ-ын Иргэдийг хүлээн авах өрөөнд нэвтрүүлээ.

Бизнес ширээний үйлчилгээнд төрийн болон бизнес хөгжлийн үйлчилгээ үзүүлэгч нийт 17 байгууллагын 97 үйлчилгээний мэдээллийн хуудсыг хамруулж, иргэдийг нэг цэгээс мэдээллээр ханган ажиллаж байгаа бөгөөд нийт 29 иргэнд энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлээд байна.

Бизнес ширээний үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд тус үйлчилгээнд хамрагдах төрийн байгууллагуудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулсны зэрэгцээ “Бизнес ширээ” үйлчилгээг сурталчлах ажлын төсөв төлөвлөгөөг боловсруулж, нийт 2,4 сая төгрөгийн санхүүжилттэйгээр сурталчилгаа мэдээллийн ажлыг зохион байгуулав. Үүнд: Танилцуулга боршур 400 ширхэг, мэдээллийн сангийн программ хангамж 1, цахим хуудас 1, мэдээллийн солигддог самбар 2, телевизийн нэвтрүүлэг 1, шторк 1-ийг тус тус хийж байрлуулсан.

Монгол Улсын Засгийн Газрын ХЭГ-аас шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоог сүүлийн 7 жилийн байдлаар харуулбал:

№	Захидал шилжүүлсэн байгууллага	2004	2005	2006	2007	2008	2009	2010
1	ЗГХЭГ	6	6	5	4	4	2	2

Иргэдэд төрийн үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, зөвлөж ажиллах “Нээлттэй утас” болон “Саналын хайрцаг”-ийг ажлын өдрүүдэд тогтмол ажиллуулж байгаа бөгөөд нээлттэй утсаар аймгийн хэмжээнд нийт 6787, саналын хайрцагаар 1074, санал асуулгын хуудсаар 4536, телевизийн шууд нэвтрүүлгээр 133, цахим шуудангаар 687 санал, хүсэлт ирсэн байна.

Иргэдээс амьжиргааны баталгаа алдагдаж, амьдралын гачигдалтай байдлаа дурьдан тэтгэмж, тусламж хүссэн болон олон улсын чанартай тэмцээн уралдаанд

оролцох, бие даасан тоглолтоо зохион байгуулахад тусламж хүссэн нийт 1038 иргэний санал, хүсэлтийг судлан үзээд аймаг, сумдын Засаг даргын захирамжаар нийт 461 иргэнд буцалтгүй тусламж үзүүлээ.

“Сахилга дэг журам, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” МУ-ын Засгийн Газрын 2007 оны 12 сарын 17-ны өдрийн 13-р албан даалгавар болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг сар бүр зохион байгуулахаар хуваарь гаргаж, хуваарийн дагуу 2010 онд Дархан, Орхон, Шарын гол, Хонгор сум, аймгийн ЗДТГ-ын ХЗХэлтэс, ЦГ, ШШГА, ШША, ОБГ, УБХ, ХХҮХ, НДХ, ЭМГ, БТСГ, ХТХ, БСГ, Гаалийн алба, Статистикийн хэлтэс, Татварын хэлтэс зэрэг 16 байгууллага Нээлттэй өдөрлөгөө зохион байгуулж, нийт 46 төрлийн арга хэмжээнд 56874 иргэн, 273 төрийн болон ТББ, 342 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, 2720 иргэний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж, давхардсан тоогоор төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудаар 195 удаа мэдээлэл сурталчилгаа хийсэн байна.

Аймгийн Засаг дарга Г. Эрдэнэбат жил бүрийн 10 дугаар сард сумдын иргэд хөдөлмөрчидтэй уулзаж, ирэх жилийнхээ ажлын төлөвлөгөө, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтыг тодорхойлоход иргэдийн санал бодлыг тусгадаг уламжлал ёсоороо Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын нийт 450 гаруй иргэдтэй баг дээр нь очиж уулзаж, санал, хүсэлтийг нь сонссоны зэрэгцээ иргэдийн санал, хүсэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

## **2. Сумдын ЗДТГ-аас иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх талаар зохиосон ажлын тухай**

Сумдад нийт 37516 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авсны 10,5 хувь нь амаар, 89,4 хувь нь бичгээр ирүүлсэн байна. Сумдын ЗДТГ нь нийт ирсэн өргөдлийн 34,1 хувийг мэргэжлийн болон дээд шатны байгууллагад, 1,65 хувь буюу 621 өргөдлийг цагдаа, шүүх, арбитрын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэн байна. Ажил хүссэн 1645 иргэний өргөдлийг судлан үзэж 897 иргэнийг ажилд зуучилсан байна. Тухайлбал Дархан сум 819, Хонгор сум 27, Шарын гол 27, Орхон сумын ЗДТГ 4 иргэнийг ажилд зуучилсан байна.

Дархан сумын хувьд тус сумын 1 иргэнд Дэлхийн Зөн ОУБ-аас иж бүрэн гэр олгосон байна. Байгаль орчны чиглэлээр 65 гомдол, 138 санал ирснээс байгаль орчны бохирдол, гудамж талбай, далан жалганы хог хаягдалтай холбоотой асуудлуудыг аймгийн НААҮГ, БОАЖГ-т тус тус уламжиллаа. Хөдөө аж ахуйн чиглэлээр 1006 иргэнээс хүсэлт ирсний дагуу “Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 800 өрхөд үрийн төмс, 50 бүлгийн 120 гаруй өрхөд хөнгөлөлттэй үнээр хүлэмж олголоо.

Хонгор сумын хувьд “Санал хүсэлтийн хайрцаг ажиллуулах журам” боловсруулж, саналын хайрцгийн тогтмол ажиллагааг ханган ажиллаж байна. Ажилд орохыг хүссэн 27

иргэний хүсэлтийг Дархан Төмөрлөг ТӨХК-д уламжилсан. Сум болон багийн Засаг даргын захирамжаар нийт 8 иргэнд 170,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлээ.

Шарын гол сумын хувьд нийт өргөдлийн 40 гаруй хувийг нийгмийн халамжийн төрөлжсөн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн хүсэлтүүд эзэлж байгаа бөгөөд дээрх үйлчилгээнүүдэд нийт 34,02 сая төгрөг зарцуулсан байна. Сумын Засаг даргын захирамжаар 36 иргэнд тус бүр 15000 төгрөгийн тусламж үзүүлээ.

Орхон сумын ЗДТГ-т ажил хүссэн 7 иргэний өргөдөл хүсэлт ирснийг судлан үзээд 4 иргэнийг ажлын байраар хангаж, 3 иргэнийг нөөцөд бүртгээд байна. Сумын Засаг даргын захирамжаар 11 иргэнд 265000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.

### **3. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагуудаас иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх талаар зохиосон ажлын тухай**

Хотын Захирагчийн албанд зөвшөөрөлгүй барьсан хашааг буулгуулах, дээвэр засуулах, эрчим хүчний хэрэглээ, СӨХ-дын үйл ажиллагаа болон ундны усны талаар нийт 118 санал гомдол ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэлээ.

Аймгийн НААҮГ нь ажилд орох тухай 127 иргэний, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1651 иргэний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ. Тухайлбал:Хог тээвэрлэх талаар 1635, Хогны үнээс чөлөөлүүлэх талаар 3, мод хэлбэржүүлэх 1, нохой устгуулах талаар 23, малын сэг зэм зөөвөрлөх талаар 1, гудамжны гэрэлтүүлэг тавиулах талаар 4, Гэрэл асахгүй байгаа талаар 4, хот дотор мал их байгаа талаар 1, хогийн цэгийн асуудлаар 1 санал, хүсэлт ирснийг шийдвэрлэн ажиллалаа.

Аймгийн Цагдаагийн газарт гэмт хэргийн тухай 1344 гомдол, мэдээлэл хүлээн авч, 696 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгалаа. Нийт гомдол, мэдээллийн 16 буюу 1,1 хувь нь хүний амь нас хохироосон, 95 буюу 7,0 хувь нь золгүй учрал, 268 буюу 19,9 хувь нь иргэдийн эрх, эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 204 буюу 15,1 хувь нь хулгай, 16 буюу 1,1 хувь нь булаалт, 38 буюу 2,8 хувь нь дээрэм, 44 буюу 3,2 хувь нь залилан, 54 буюу 4,0 хувь нь танхай, 82 буюу 6,1 хувь нь авто осол, 499 буюу 37,1 хувь нь бусад хэрэг, зөрчил байна.

Аймгийн ТАЗГазарт Нээлттэй утас тогтмол ажиллаж, иргэд тээвэрчдэд үнэн зөв мэдээллийг шуурхай өгч ажиллаж байна.

Иргэдээс зорчигч тээврийн үйлчилгээний соёлын талаар 18 санал, гомдол ирснийг нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг гэрээт байгууллагуудад уламжлан холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны нээлттэй утсанд нийт 54, бичиг хэрэгт 92 өргөдөл, хүсэлт ирсэн ба саналын хайрцгаар болон санал асуулгын хуудсаар 97 санал ирсэн байна. Санал асуулгад оролцсон нийт иргэдийн 70 гаруй хувь нь тус байгууллагыг нэгдсэн байртай болж, төвлөрсөн үйлчилгээг хүргэх шаардлагатай байгааг, 30 гаруй хувь нь үйлчилгээнд талархалтай байгаагаа илэрхийлсэн байна.

Аймгийн БОАЖГазар нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хувийн барилга байгууламж, үйлчилгээний газартаа хийлгэхээр хүсэлт гаргасан 103 иргэнд зохих журмын дагуу үнэлгээ хийж, өргөдлийг шийдвэрлэсэн. Тус газрын нээлттэй утсаар Хараа голын дагуу хог хаягдал их хаяж байгаа талаар болон Дархан сумын нутаг дэвсгэр 8-р багт барилгын хог хаягдал ихээр хуримтлагдсан байгаа талаар тус тус гомдол, мэдээлэл ирснийг Дархан сумын байгаль хамгаалагчид мэдэгдэж хяналт тавьж ажиллаж байна. Ажилд орохыг хүссэн 3 иргэний өргөдөл хүсэлтийг судлан үзээд жолооч, архив бичиг хэргийн ажилтан, Хонгор сумын байгаль хамгаалагчаар тус тус томилон ажиллуулсан.

Аймгийн ХХААЖДҮГ-т чацарганы суулгац зээлээр олгох, хүлэмжийн аж ахуй эрхлэх, хүлэмжийн захиалгад орох, хүнсний ногоо тариалах талаар зөвөлгөө авах, “Монгол төмс” хөтөлбөрт хамрагдах, зохиомол хээлтүүлэг хийлгэх, бага оврын трактор болон тусламжаар ирсэн малын тэжээлийн будаанаас олгуулах талаар тус тус өргөдөл, хүсэлт ирснийг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажиллалаа. Жижиг дунд үйлдвэрлэлийг хэрхэн дэмжих, зээлд хэрхэн хамрагдах талаар зөвөлгөө, мэдээлэл хүссэн хүсэлтүүдийг аймгийн дэд комисс хүлээн авч, холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэж зөвлөгөө өгч ажиллалаа.

Иргэдийн хүсэлтээр аймагт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон зах зээлийн газруудыг 7 хоног бүрийн нэг өдөр амруулж байх эсэх талаар түрээслэгч иргэдээс санал асуулга авч аймгийн Засаг даргын 2010 оны 393 дугаар захирамжаар шийдвэрлэлээ.

Аймгийн Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний хэлтэст тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой өргөдлүүдээс гадна Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес эрхлэх ажлын байрны асуудлыг шийдвэрлэж өгөх тухай, мөнгөн тусламж, орон гэр болон Хүний хөгжил сангийн хишиг хувийн тухай нийт 57, ажлын байрны тухай 2, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах асуудлаар 2 санал, хүсэлт ирснийг шуурхай барагдуулан ажиллалаа.

Аймгийн Нийгмийн Даатгалын хэлтэст хувийн хэвшлийн зарим байгууллагууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгодог тухай 15, ажилласан жилээ хянуулах тухай 2, тэтгэврийн хэмжээгээ хянуулах 59, ажилласан жилээ нэмэгдүүлэх 128, ажил хүссэн 2 иргэний өргөдөл хүсэлтийг тус тус хүлээн авч шийдвэрлэлээ.

Аймгийн Боловсрол Соёлын Газарт цэцэрлэгийн багш, удирдах ажилтны ёсзүй, харилцааны соёлын талаар 7 гомдол ирсний дагуу тухайн байгууллагууд дээр газар дээр нь очиж шалгаж, холбогдох албан тушаалтнуудад сануулах арга хэмжээ авсан байна. Ажилд орохыг хүссэн 11 өргөдөл ирсний 10 өргөдлийг боловсрол, соёлын салбарын хүний нөөцийн бүртгэлд бүртгэн авч, 1 иргэнийг ажилд авсан байна.

Аймгийн Эрүүл Мэндийн Газар нь эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхтэй холбоотой 2 гомдлын мөрөөр Шарын гол сумын эмнэлгийн 2 эмчид цалингийн хувиар торгох, сануулах арга хэмжээг тус тус авлаа. Эмчийн ёс зүйн асуудлаар 2 өрхийн эмнэлэгт холбогдох гомдлыг хүлээн авч, аймгийн ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг ажиллаж, 25 зөрчил илрүүлэн засах хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

Ажилд орохыг хүссэн 100 иргэний хүсэлтийг хүлээн авч, 26 иргэнийг аймгийн ЭМГазар, болон өрхийн эмнэлгүүдэд ажлын байраар хангалаа.

Аймгийн Хүүхдийн Төлөө Хэлтэс нь аймгийн Цагдаагийн газарт уламжлан шийдвэрлүүлсэн ял хойшлуулах тухай 24 иргэний өргөдөл болон сургуульд хамруулахыг хүссэн 9, эмчилгээний зардал хүссэн 3, тэргэнцэр хүссэн 10, гэр хүссэн 4, бичиг баримтын зөрчил арилгуулах 23, хүүхдийн эрх зөрчсөн тухай 16, асран хамгаалагч цуцлуулах тухай 2, Олон улсын хүүхдийн Найрамдал төвд амрах тухай 1, шагнах тухай 1, цэцэрлэгийн тоглоом шинэчлэх тухай 2, нийт 133 өргөдөл хүсэлтийг хүлээн авч, 148 хүүхдийн асуудлыг шийдвэрлэн ажиллалаа.

Аймгийн Татварын хэлтсийн нээлттэй утсаар өдөрт 10-15 иргэн үйлчлүүлж, мэдээлэл зөвөлгөө авдаг бөгөөд нийт 1061 иргэн уг утсанд хандсан байна. Татвар төлөгч иргэдтэй цахим хэлбэрээр харилцах боломжийг бүрдүүлэн ажиллаж, нийт 200 татвар төлөгчийн цахим хаягийг бүртгэн авч, тогтмол харилцаж хэвшээд байна. Ажил хүссэн 3 иргэний хүсэлтийг судлан үзэж, төрийн албан хаагчийн мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн нөөцөд бүртгэлтэй 1 иргэнийг ажилд томиллоо.

Аймгийн Стандарт Хэмжилзүйн Хэлтэс нь Мэргэжлийн Хяналтын газрын улсын байцаагчийн протоколоор 28 гомдол, 9 хүсэлт хүлээн авч, 17 байгууллага, иргэний бүтээгдэхүүнд шинжилгээ хийж, холбогдох хариуг хүргүүлсэн байна. Мөн 230 гаруй иргэд аж ахуйн нэгжийн хүсэлтээр хяналтын дээжинд шинжилгээ хийж үйлчиллээ.

Аймгийн Мэргэжлийн Хяналтын газарт дүгнэлт гаргуулах тухай 370, газрын маргаантай холбоотой 29, цалин хөлстэй холбоотой 39, боловсролын баримт бичиг гээгдүүлсэн 42, актын тайлбар 19, дээврээс ус алдсан тухай 20 өргөдөл гомдол ирүүлснийг тус тус шалган шийдвэрлэлээ.

Цэргийн штабт хугацаат цэргийн албан хаагчдаас орон нутгийн чөлөө хүссэн 12 архивын лавлагаа хүссэн 1, цэргийн албанаас чөлөө хүссэн 95, гэрээт цэрэгт явах тухай 10, дүйцүүлэх албанд элсэх тухай 7 хүсэлтийг тус тус шийдвэрлэлээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын асуудлаар иргэдээс санал хүсэлт ирээгүй байна.

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Т. ГАНБОЛД

МЭДЭЭГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

О. БУЯНАА

Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын дарга

Ч. Хүрэлбаатар танаа

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх талаар 2010 онд зохиосон ажлын тайлан”-г хавсралтаар хүргүүлэв.

Хавсаргасан материал : ..... хуудас

Дарга

Т. Ганболд

: